



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНМӨНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/35

Улаан эрэг

“Тэр бум мод” тарих үндэсний хөдөлгөөн
зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 58 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тэр бум мод тарих үндэсний хөдөлгөөн зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Байгаль орчны Улсын байцаагч

Гишүүд:

Байгаль хамгаалагч

Хөдөө, аж ахуйн тасгийн мэргэжилтэн

1-р багийн Засаг дарга

2-р багийн Засаг дарга

3-р багийн Засаг дарга

4-р багийн Засаг дарга

Ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтан

Эрүүл мэндийн төвийн нярав

Орон нутаг судлалын танхимын ажилтан

Цэцэрлэгийн жижүүр

2.Тэр бум мод үндэсний хөдөлгөөнийг сум орон нутагтаа чанартай зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.НЯМДАВАА